



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 онь 06 сарын 18 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Төсөв батлах тухай” 02 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмын 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тулгар төрийн 2228, Их Монгол улсын 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд үндэсний их баяр наадмын тохижилт, засвар, гэрэлтүүлэг, био жорлонг нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.


2. Худалдан авах ажиллагааны задаргааг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгож, гүйцэтгэгчийг шалгаруулж, ажиллахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР




Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
ММН дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Т.Туул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Билгүүн	Сүхбаатар дүүрэг 10 дугаар хорооны 7-р хороолол 21-28 оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	О.Оджаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн
А/171 дугаар тушаалын 06 дугаар хавсралт



ТУЛГАР ТӨРИЙН 2228, ИХ МОНГОЛ УЛСЫН 813, АРДЫН ХУВЬСГАЛЫН
98 ЖИЛИЙН ОЙ, ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТОХИЖИЛТ,
ЗАСВАР, ГЭРЭЛТҮҮЛЭГ, БИО ЖОРЛОНГ НИЙЛҮҮЛЭХ
АЖЛЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАДАРГАА

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Төсөвт өртөг /сая.төг/	2019 онд санхүүжих /сая.төг/	Хугацаа
1	2	3	4	5
Тохижилт, засвар үйлчилгээний ажил				
1	Төв цэнгэлдэх хүрээлэн болон Хүй долоон худагт байрлуулах 40 ширхэг био жорлон худалдан авах ажил	102.000.000	102.000.000	2019.06.20 2019.07.05
2	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн 18 ширхэг гэрэлтүүлэг хийх ажил	133.600.000	133.600.000	2019.06.20 2019.07.05
3	Хүй долоон худгийн шуудуун дээр гарах 10 ширхэг модон гүүрэн гарц хийх ажил	20.000.000	20.000.000	2019.06.20 2019.07.05
НИЙТ		255.600.000	255.600.000	